

## ЯПОН УЛСАД ОРШИН СУУЖ БУЙ БҮХ ГАДААДЫН ИРГЭДИЙН АНХААРАЛД

Монгол хэл (モンゴル語)

2012 оны 7 дугаар сарын 9-нөөс эхлэн:

Оршин суух менежментийн системийг шинэчлэж байгаатай холбогдуулан “Оршин суугчийн үнэмлэх”-ийг хэрэглэж эхлэх бөгөөд Гадаадын иргэний бүртгэлийн карт буюу Тоорокүшоомэйшо-г хэрэглээнээс гаргах болно.

### Оршин суугчийн үнэмлэх:

- Энэ нь хэнд хамааралтай вэ: Япон улсад 3 сараас илүү хугацаатайгаар оршин суух эрх бүхий гадаадын иргэдэд олгох болно.
  - Түр зуурын буюу Зочлох статус бүхий иргэд, Дипломат болон Албан Ёсны статустай иргэдэд олгохгүй.
  - Оршин суух тусгай эрх бүхий статустай иргэдэд Оршин суугчийн үнэмлэхийн оронд Оршин Суух Тусгай Эрхийн гэрчилгээ олгоно.
- Агуулах мэдээлэл: Энэхүү үнэмлэх нь цээж зураг болон овог нэр, үндэстэн, бүс нутаг, төрсөн огноо, хүйс, оршин суух статусын төрөл, байх хугацаа болон ажиллах эрхтэй эсэх зэрэг мэдээллийг багтаана.
- Хүчинтэй хугацаа:

	16-гаас дээш насныханд	16-гаас доош насныханд
Байнгын оршин суугчид	Олгосон огнооноос 7 жил	Иргэний 16 насны төрсөн өдөр хүртэл
Байнгын оршин суугчдаас бусад	Байх хугацаа дуусах хүртэл	Байх хугацаа дуусах эсвэл 16 насны төрсөн өдөр хоёрын аль түрүүлэх хүртэл нь

- Олгох газар:
  - Бүс нутгийн цагаачлалын газар: Оршин суугчийн үнэмлэхийг 2012 оны 7 дугаар сарын 9-нөөс эхлэн Нарита, Ханэда, Чүүбү, Кансай зэрэг нисэх онгоцны буудлуудад дунд болон удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй иргэдэд олгож эхлэнэ. Харин эдгээрээс бусад хилээр орж, гарч байгаа иргэдэд Оршин суугчийн үнэмлэхийг нь Япон улсад орж ирэх үед бүртгэлтэй хаягаар нь тухайн хотын бүртгэлийн газраас нь баталгаатай шуудангаар явуулна. Илүү мэдээлэл авахын тулд Бүс нутгийн цагаачлалын алба, Дүүргийн цагаачлалын алба эсвэл салбар бүртгэлийн газартаа хандана уу.
- Хэдэн сарын хэднээс өмнө Гадаад иргэний бүртгэлийн карт буюу Тоорокүшоомэйшо-г Оршин суугчийн үнэмлэх болгож сольсон байх хэрэгтэй вэ?
  - Оршин суугчийн үнэмлэхийг олготол тодорхой хугацаанд Гадаад иргэний бүртгэлийн картыг хэрэглэсэж байж болох ба Оршин суугчийн үнэмлэхтэй адил зорилгоор ашиглаж байж болно. Заавал шууд Оршин суугчийн үнэмлэхээ авах шаардлагагүй гэсэн үг.
  - Оршин суух хугацаагаа сунгуулах үед Цагаачлалын газраас ахин шинээр Оршин суугчийн үнэмлэхийг олгоно.
  - 16 буюу түүнээс дээш настай байнгын оршин суугчид 2015 оны 7 дугаар сарын 8-ны дотор\*, харин 16-гаас доош насны байнгын оршин суугчид 2015 оны 7 дугаар сарын 8 юмуу эсвэл 16 насныхаа төрсөн өдөр хоёрын аль түрүүлж болох өдрийн дотор оршин суугчийн үнэмлэхээ солиулсан байх шаардлагатай.
 

\*Анхааруулах нь: Дөрөв болон таван жилийн хугацаатай тодорхой үйл ажиллагаа явуулах эрх бүхий статустай гадаадын иргэд ч мөн адил 2015 оны 7 дугаар сарын 8-наас өмнө Оршин суугчийн үнэмлэхээ авах шаардлагатай.
- Яавал хялбар байх вэ?
  - Оршин суугчийн үнэмлэх болон паспорттай иргэд нэг жилийн дотор Японд эргэн ирэх буюу байж болох зөвшөөрөгдсөн хугацаандаа\* буцаж ирэх тохиолдолд заавал дахин орох зөвшөөрөл буюу

Re-Entry Permit авах шаардлагагүй. Үүнийг “Дахин орох тусгай зөвшөөрлийн систем” хэмээн нэрлэж байгаа юм. Харин визийн хүчинтэй хугацаандаа буцаж Японд ирээгүй иргэдийн оршин суух статус хүчингүй болно. Мөн түүнчлэн Дахин орох тусгай зөвшөөрөл нь гадаадын оронд байх хугацаанд сунгагдах боломжгүй болохыг анхаарна уу.

\*Анхааруулах нь: Оршин суух тусгай эрх бүхий статустай хүмүүст дахин орох тусгай зөвшөөрөл нь хоёр жилийн дотор хүчинтэй байх юм.

### Оршин суух гэрчилгээ

Оршин суугчийн үнэмлэх эсвэл Оршин суух тусгай эрхийн гэрчилгээ авах эрхтэй гадаадын иргэдэд Япон иргэдэд олгодгийн адилаар Оршин суух гэрчилгээг өөрийн харьяалагдах хотын захиргаанаас нь олгох болно.

- Агуулах мэдээллүүд:

Оршин суух гэрчилгээн дээр овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, хаяг болон гадаадын иргэдэд хамааралтай үндэс, угсаа, оршин суух статус, байх хугацаа зэрэг байна.

- Оршин суух гэрчилгээг хаанаас олгох:

Гадаадын иргэд Оршин суух гэрчилгээ аль эсвэл Иргэний Бүртгэлд Бүртгэгдсэн Зүйлсийн гэрчилгээг өөрийн харьяалагдах хотын захиргаанаас Япон иргэдийн адил авах боломжтой.

\*Ерөнхий Иргэний Бүртгэлийн Системийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Дотоод хэрэг, Харилцааны Яамны доорх холбоосоор орж үзнэ үү.

[http://www.soumu.go.jp/main\\_sosiki/jichi\\_gyousei/c-gyousei/zairyu.html](http://www.soumu.go.jp/main_sosiki/jichi_gyousei/c-gyousei/zairyu.html)

### Доорх тохиолдлуудад өргөдөл маягт бөглөж байж авах шаардлагатай:

Байдал	Хаашаа очих
1. Шинэ хаяг аль эсвэл хаягаа өөрчлөх гэж байгаа тохиолдолд Шилжин ирж буй мэдэгдэл*, Хаяг солих мэдэгдэл*, Шилжин явах мэдэгдэл** * Оршин суугчийн үнэмлэх, Оршин суух тусгай эрхийн гэрчилгээ (аль эсвэл Гадаадын иргэний бүртгэлийн картаа буюу Тоорокүшоомэйшо-г) авчирна уу. ** Хэрвээ одоо байгаагаасаа өөр хотын захиргаа руу нүүх гэж байгаа бол оршин сууж байсан хотын захиргаандаа Шилжин явах мэдэгдэл өгөх хэрэгтэй.	Оршин суугаа хотын захиргаанд
2. Овог нэр болон иргэншлээ солих тохиолдолд	Бүс нутгийн цагаачлалын албанд хандах
3. Оршин суугчийн үнэмлэхээ үрэгдүүлсэн, аль эсвэл дахин хэрэглэх боломжгүйгээр гэмтээсэн тохиолдолд	
4. Байнгын оршин суугчид болон 16 хүртэлх насны иргэд: • Одоо байгаа Оршин суугчийн үнэмлэхийн хугацаа нь удахгүй дуусахаар байгаа бол	
5. Ажиллах статустай иргэд (бүгд хамаарахгүй), оюутан болон дадлагажигч нар: • Таны хамааралтай байгууллага болох сургууль эсвэл ажлын газар өөрийн нэр, хаягаа өөрчлөх, дампуурах, ажлын гэрээт хугацаа дуусах, шинээр өөр ажлын газартай гэрээ хийх тохиолдлуудад	Бүс нутгийн цагаачлалын газар руугаа өөрийн биеэр ирж мэдэгдэх, аль эсвэл Токиогийн Бүс нутгийн цагаачлалын албанд шуудангаар илгээх
6. Дараах статустай иргэд: Хамаарагч (эхнэр, нөхөр гэх мэт), Томилогдсон/тусгай үүргийн ажил хийх (С), Японы иргэний эхнэр, нөхөр аль эсвэл хүүхэд бол, эсвэл байнгын оршин суугч: • Эхнэр нөхрөөсөө салах, эсвэл нас барсан тохиолдолд	

**Японоос бусад хэлээрх лавлагаа: Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол дараах газруудад хандана уу.**

<p>➤ Цагаачлалын Албаны Мэдээллийн Төв Даваа-Баасан, 8:30-17:15 Утас: 0570-013904 (IP Утас, PHS, Олон Улсын Дуудлага: 03-5796-7112)</p>	<p>Харилцах боломжтой хэлүүд: Англи, Хятад, Солонгос, Испани, Португал</p>
<p>➤ Нэг цэгийн зөвлөгөө, туслалцаа авах төв Даваа-Баасан, 9:00-16:00 Гадаадын иргэдэд зориулсан Зөвлөгөө туслалцааны төв (Шинжүкү): 03-3202-5535 Сайтама Мэдээлэл, Тусламж: 048-833-3296 Хамамацү Олон Үндэстний Соёлын төв, нэг цэгийн үйлчилгээний цэг: 053-458-1510 Веб хаяг: <a href="http://www.immi-moj.go.jp/info/index.html">http://www.immi-moj.go.jp/info/index.html</a></p>	<p>Утсаар болон биеэр ирж зөвлөгөө авах тохиолдолд японоос бусад хэлээр авах боломжтой. Ямар хэлээр зөвлөгөө авч болох нь долоо хоногийн гариг бүрээс шалтгаалж өөр байх тул веб хуудаснаас эхлээд үзнэ үү. <u>Шинжүкү:</u> Англи, Хятад, Испани, Португал, Бенгаль, Вьетнам, Индонез <u>Сайтама:</u> Англи, Португал, Испани, Хятад, Солонгос, Тагалог, Тай, Вьетнам <u>Хамамацү:</u> Англи, Португал, Испани, Хятад, Тагалог</p>

Цагаачлалын алба, Хууль Зүйн Яам: Оршин суух менежментын шинэ системын талаар  
[http://www.immi-moj.go.jp/newimmiact\\_1/index.html](http://www.immi-moj.go.jp/newimmiact_1/index.html) холбоосоор хандана уу.

\*Англи, Хятад (Хялбарчилсан болон Уламжлалт), Солонгос, Испани, Португал хэлээрх хувилбарууд байгаа болно.

Орчуулгыг: Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль